



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГА Д.ОРОСОО ТАНАА

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ц.Жигжиджавын гудамж 9, "Хангарьд ордон",
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.mn; http://www.city.audit.mn

2013.03.07 № 587

танай _____-ны № _____-т

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянгол дүүргийн орон нутгийн төсвийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан болон холбогдох илчлэл тодруулгад Нийслэлийн аудитын газрын санхүүгийн аудитын III баг аудит хийлээ.

Үүрэг хариуцлагын талаархи мэдэгдэл

Баянгол дүүрэг орон нутгийн төсвийн санхүүгийн нэгдсэн тайлангаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэгтэй.

Санхүүгийн нэгдсэн тайлан Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), Сангийн сайдаас баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналын заавар, журмын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, Монгол Улсын Үндэсний Аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлсийг сорилын үндсэн дээр шалгадаг. Баянгол дүүргийн удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, баримталсан бодлого, хийсэн чухал тооцоолол, санхүүгийн нэгдсэн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн нэгдсэн тайланд дүгнэлт өгөх үндэслэл болсон.

Монгол Улсын төсвийн байгууллагуудад мөрдүүлж байгаа Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын заавар, журам нь УСНББОУС-ын заримтай нийцэхгүй байна. Тухайлбал: Төсвийн байгууллагууд санхүүгийн тайлангаа аккруэл сууриар бус, аккруэл-мөнгө хольсон

сууриар тайлагнаж байхаар журамласан нь авлага, өглөг, хөрөнгө, тайлант үеийн орлого, зардал, үр дүнгийн үзүүлэлтүүд олон улсын стандартаас зөрүүтэй илэрхийлэгдэх магадлалтай.

Сангийн яамнаас нэгэнт бүх төсөвт байгууллагуудад дээрхи заавар журмыг мөрдүүлсэн учраас санхүүгийн нэгдсэн тайланг түүнтэй нийцүүлэн аудит хийв.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл:

2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд залруулагдаагүй дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Төрийн банкинд байршуулсан төлбөрийн картны дансны оны эхний үлдэгдэл 19,047.9 мянга, эцсийн үлдэгдэл 365.1 мянга нийт 19,413.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй.

- 2012 онд орсон бэлэн мөнгөний орлогыг Төрийн банкны картан дансны хуулгатай тулгахад Засаг даргын Тамгын газар 20,098.5 мянга, Засаг даргын нөөц сан 7,345.0 мянга, тендерийн баримт бичиг борлуулсны орлогын 541.5 мянга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 3,446.3 мянга, гэрэлтүүлэг тохижилт үйлчилгээний сан 966.5 мянга, төлбөрийн дансны үлдэгдэлд тооцож олгосон 669.9 мянган төгрөгийн хүүгийн орлого нийт 33,067.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.

- Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дансанд бүртгэлтэй 46,827.0 мянган төгрөгийн 33 ширхэг зөөврийн компьютер дутагдсан.

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга тэтгэвэрт гарахтай холбогдуулан 36-н сарын цалингийн сантай тэнцэх хэмжээний 30,000.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олгосон.

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 40,000.0 мянга, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 28,000.0 мянга нийт 68,000.0 мянган төгрөгөөр төлөөлөгч нар болон ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдсэн.

- Засаг даргын Тамгын газар нь хороодын шинэ жилийн үйл ажиллагаанд 1,250.0 мянга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэхэд 3,402.5 мянган төгрөгийг тэтгэмж, урамшууллын зардлаас тус тус зарцуулсан.

- Засаг даргын нөөц сангаас 66,458.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

- Гамшгаас хамгаалах сангийн бэлэн мөнгөний үлдэгдэл 10,390.0 мянган төгрөг, "Баянгол сэлбэ" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 23,106.3 мянган төгрөгийн өглөгүүдийн эцсийн үлдэгдлийг холбогдох байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

- Хог хаягдлын сан нэрээр үйл ажиллагаа эрхэлж байгаад татан буугдсан сангийн 22,743.3 мянган төгрөгийн хог тээвэрлэлтийн хөлсийн өглөгийн үлдэгдэлээс дүүргийн шүүхийн шийдвэрээр 20,243.3 мянган төгрөгийг "Гурван ташир" ХХК-д, 2,500.0 мянган төгрөгийг "Сүхбаатар тохижилт" ХХК-д гэрэлтүүлэг, тохижилт үйлчилгээний сангаас зориулалт бусаар тус тус төлсөн.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурьдсан зүйлсийн болзошгүй үр нөлөөг эс тооцвол Баянгол дүүргийн орон нутгийн төсвийн 2012 оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж мөн оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн нэгдсэн тайлангийн санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой заавар журмын, дагуу материаллаг зөрчилгүй толилуулсан байна.

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
АУДИТОР



Ц.ОЧИРБАТ